



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 01/403

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 26 дугаар сургуулийн
барилга данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 109 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/924 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2017 оны 02-07-096/67, 2020 оны 02-07-135/430 тоот дүгнэлтээр тус тус ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Хан-Уул дүүргийн 26 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй хавсралтад заасан нийт 4,250,080.00 /дөрвөн сая хоёр зуун тавин мянга наян/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгуудыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 26 дугаар сургууль /Д.Энхтайван/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой хөрөнгийг худалдан борлуулахаар үнэлсэн 260,000.0 /хоёр зуун жаран мянган/ төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ГНЭНБАТ

115050000973

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн
01/403 дугаар тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН
ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Жижүүрийн байр	56	м2	16	63,000.0	1,008,000.0	1,008,000.0	-
2	Агуулах	56	м2	18	50,600.0	910,800.0	910,800.0	-
3	Манааны байр	56	м2	2,3	67,600.0	155,480.0	155,480.0	-
4	Аж ахуйн склад	56	м2	43	50,600.0	910,800.0	910,800.0	-
Нийт дүн						4,250,080.0	4,250,080.0	-